



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/605

Улаанбаатар хот

Хяналтын баг, инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Барилгын тухай Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 /Багц-1/, Захиргааны барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 /Багц-2/, Нисэх буудлын үйлчилгээний барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 /Багц-3/, Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна ачаа, шуудан буулгах, ачих талбайн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх ИНЕГ/УТ/ТББ/А-07/18 дугаар гэрээт ажилуудад хяналт тавих захиалагчийн хяналтын багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Багийн ахлагч:

Н.Мягмарсүрэн

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Дэд бүтэц, техник ашиглалт хариуцсан дэд дарга

Нарийн бичгийн дарга:

П.Сүхболд

Худалдан авах ажиллагааны тасгийн аэродромын инженер

Гишүүд:

Г.Мөнхболд

Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хяналтын инженер:

Э.Мөнх-Эрдэнэ

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны аэродромын ашиглалтын инженер

2. Гэрээт ажилд эрх бүхий байгууллагаас мэргэжлийн зөвлөгөө авах, хөндлөнгийн байгууллагаар материал болон геодезийн хяналт хийлгэх зардал, гэрээт ажлуудын явцад хяналт тавих, ашиглалтад авахтай холбогдон гаргах бусад зардлыг гэрээт ажлын захиалагчийн хяналтын зардлаас гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Хяналтын багийн ажлын үр дүнг 14 хоног тутам Тэргүүн дэд даргад танилцуулахыг Хяналтын багийн ахлагч /Н.Мягмарсүрэн /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

The stamp is a red rectangular seal. It contains Mongolian text arranged in columns. On the left side, there are two columns of text. In the center, there is a circular emblem with a central symbol. On the right side, there are two columns of text. The text appears to be a name and a title, corresponding to the labels 'ДАРГА' and 'Л.БЯМБАСҮРЭН' on either side of the stamp.